



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/52

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 17, 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.4, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар 22-ны А/490 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газарт шаардлагатай бараа, материалын үнэ, нэр төрөл, тоо хэмжээг нэгдүгээр, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулж, дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (хошууч Ж.Төмөрмандах)-д үүрэг болгосугай.
3. Тендерийн баримт бичиг бэлтгэх, техникийн тодорхойлолт боловсруулах, тендер зарлах, хүлээн авах, хянан үзэхэд шаардлагатай зардал болон үнэлгээний хорооны дарга, гишүүд, зөвлөхөд олгох урамшуулал, ажил үйлчилгээний хөлс, техник хяналтын зардлыг тендерийн баримт бичиг худалдсан орлогоос гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн
11715560 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ХУДАЛДАН АВАХ БАРАА, МАТЕРИАЛЫН ҮНЭ,
НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ

Тендерийн дугаар	Багцын дугаар	Худалдан авах бараа, материал	Тендерийн төрөл	Барааны			
				Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Бүгд үнэ /төг/
НБ-19-01	1	Хүн тээвэрлэх зориулалтын УАЗ-22069	Нээлттэй	ширхэг	2	35.000.000	70.000.000
	2	Туулах чадвар сайтай 4 дугуйт		ширхэг	3	34.333.000	102.999.000
	3	Үүргийн гал унтраагуур РЛО		ширхэг	100	500.000	50.000.000
Нийт дүн					105	69.833.000	222.999.000

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 06 дугаар сарын 07 -ны өдрийн
15 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



НБ-19-01 ДҮГЭЭР ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:

Ж.Төмөрмандах

Нийслэлийн Онцгой байдлын газрын Дотоод хяналт,
шинжилгээ, үнэлгээ, эрсдэлийн удирдлагын тасгийн
дарга, хошууч,

Үнэлгээний хорооны гишүүд:

Г. Галбадрах

Онцгой байдлын ерөнхий газрын Санхүү, хөрөнгө
оруулалтын газрын тасгийн дарга, хошууч,

А.Ариунсанаа

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын
худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн,

.....

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын
тэргүүлэгчдийн 79 дүгээр тогтоолоор томилогдсон
иргэн,

Нарийн бичгийн дарга:

Б.Сэрдамба

Санхүү, эдийн засгийн хэлтсийн инженер, ахмад

---oOo---